**“НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ХЭМЖЭЭНД**
**2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ**
**2020 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН БИЕЛЭЛТИЙН МЭДЭЭ**

2020.04.09 Улаанбаатар хот

| Д/д | Зорилт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүү-лэх хугацаа | Төлөвлөгөөний биелэлт | Хэрэгжил-тийн хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 1 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан ажиллах, энэ талаарх мэдээллийг иргэд байгууллага, чөлөөтэй авах нөхцөлийг хангах | Авлигын эсрэг хууль тогтоомж болон эрх бүхий байгууллагаас авлигын эсрэг зохион байгуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааг олон төрлийн мэдээллийн хэрэгслээр нийтэд нээлттэй хэлбэрээр сурталчлах | I, II, III, IV улирал | Авлигын эсрэг хууль тогтоомжийг сурталчлан, энэ чиглэлийн мэдээ мэдээллийг байгууллагын www.khangardi.mn цахим хуудас, “Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар” пэйж хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулан ажиллаж байна.<br>Мөн Авлигатай тэмцэх газраас гаргасан албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах, түүнтэй танилцах, мэдээлэл өгөх тухай зөвлөмж бүхий шторкыг байгууллагын вэб хуудас болон фэйсбүүк хуудсанд байршуулан, олон нийтэд сурталчлах ажлыг идэвхтэй зохион байгуулж ажилласан. | 100% |
| 2 | Хүний нөөцийн ил тод байдлыг хангах, олон нийтийг түүнтэй танилцах боломжоор хангах | Сул орон тооны зар, сонгон шалгаруулалтын талаарх мэдээлэл, харилцах утасны дугаар зэргийг цахим хуудас болон мэдээллийн самбарт иргэдэд нээлттэй мэдээлэх | I, II, III, IV улирал | Сул ажлын байрны зар, холбогдох утасны дугаар, хаягийн мэдээллийг www.khangardi.mn цахим хуудас болон байгууллагын ил тод байдлын самбарт нээлттэйгээр, 14 хоногийн давтамжтайгаар шинэчлэн байршуулж байна. Мөн www.unegui.mn-д цахим хуудас болон дүүргүүдийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсээр дамжуулан 4 төрлийн ажлын байранд 6 удаагийн давтамжтай захиалга өгч ажиллалаа.<br>Зарын дагуу ирсэн ажил горилогчдоос сонгон шалгаруулалт хийх байдлаар ажлын байрны сул орон тоог нөхөж ажиллаж буй бөгөөд тодорхой ур чадвар, туршлага шаардсан ажлын байранд албан хаагч сонгон шалгаруулахдаа мерит зарчмыг удирдлага болгон ажилласнаар 2020 оны 1 дүгээр улирлын байдлаар нийт 6 ажлын байрны сул орон | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | тоонд байгууллагын ажилтан, албан хаагчийг дэвшүүлэн томилсон байна. | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 3 | Хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах, мэдээлэх, хяналт тавих ажлыг хуулийн дагуу зохион байгуулах | Мэдүүлэг гаргагч албан тушаалтны хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг, мэдэгдэл, тайлбарыг бүртгэх, хянах, хадгалах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулах | I улирал | Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу нийт 13 ажилтан 2019 оны ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд мэдүүлж, эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийн үнэн зөвийг хянаж баталгаажуулан, цахимаар илгээсэн. Хугацаа хоцорсон болон мэдүүлэг гаргаж өгөөгүй, мэдүүлэг гаргахаас татгалзсан албан хаагч байхгүй болно.<br>Мөн хөрөнгө итгэмжлэн хариуцах албан тушаалд шилжин томилогдсон 5 албан хаагчийн ХАСУМ-ийг гаргаж, АТГ-т хүргүүлсэн бөгөөд тус газраас ирүүлсэн хариуг үндэслэн албан тушаалд томилсон. | 100% |
| 4 | | Эрх бүхий албан тушаалтан, мэдүүлэг гаргагч нарт зориулсан эрх бүхий байгууллагаас зохион байгуулж буй сургалтад идэвхтэй хамруулах | I, II, III, IV улирал | Монгол улсын Засгийн газрын 2020 оны 62 дугаар тогтоолоор улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан улсын онцгой комиссын 02 дугаар тогтоолоор 2020.04.31-ний өдөр хүртэл олон нийтийг хамарсан аливаа үйл ажиллагаа, сургалт семинар зохион байгуулахыг хориглосон тул тайлант хугацаанд энэ төрлийн сургалт зохион байгуулагдаагүй болно. | Үнэлэх боломжгүй |
| 5 | Албан хаагчийн шударга байдал, түүнийг нэмэгдүүлэх | Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг олон эх үүсвэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн хугацааг богиносгох | I, II, III, IV улирал | Тайлант хугацаанд авлига, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай болон уг асуудалтай холбогдуулан гарсан ёс зүйн зөрчлийн талаар өргөдөл гомдол байгууллагад ирээгүй болно. | Үнэлэх боломжгүй |
| 6 | | Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллах | I, II, III, IV улирал | Үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг нийт ажилтан, албан хаагчид үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж буй бөгөөд ёс зүйн зөрчил гаргасан 4 ажилтанд холбогдох арга хэмжээ авах саналыг газрын даргад хүргүүлж ажилласан. Ёс зүйн зөвлөлөөс ирүүлсэн саналыг үндэслэн хөдөлмөрийн | 100% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | гэрээнд заасан ноцтой зөрчил гаргасан 2 ажилтанд сахилгын шийтгэл оногдуулсан болно. | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| 7 | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн зөвлөмж, шийдвэрийг тухай бүр биелүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | I, II, III, IV улирал | Авилгатай тэмцэх газраас ирсэн зөвлөмж шийдвэрийг дагаж мөрдөн, авилгын эсрэг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллаж, холбогдох мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудас болон пэйж хуудсанд нийтэд нээлттэй хэлбэрээр байршуулан ажиллаж байна. | 100% |
| 8 | | Авлигын эсрэг үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг нийслэлийн хөтөлбөр, байгууллагын авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг эрх бүхий байгууллагад заасан хугацаанд тайлагнах | | Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/335 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх журам"-ын дагуу төлөвлөгөөний биелэлтийг улирал бүрийн дараа сарын 10-ны өдрийн дотор НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлэн ажиллаж байна. | 100% |

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.ШИНЭЧИМЭГ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АЖИЛТАН Э.ХОРОЛДУЛАМ